



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар 243

Улаанбаатар хот

Хувьцааг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Компанийн тухай хуулийн 42 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн гаргасан нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 87,486 /наян долоон мянга дөрвөн зуун наян зургаа/ ширхэг хувьцааг хаалттай хүрээнд санал болгон гаргасан 1,805,054 /нэг сая найман зуун таван мянга тавин дөрөв/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд нэмж бүртгэн, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,892,540 /нэг сая найман зуун ерэн хоёр мянга таван зуун дөч/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦТТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоолын 1-д заасан нэмж гаргаж буй хувьцааг компанийн хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авахыг санал болгох, үнийг Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээс доошгүй байх, уг эрхийг хэрэгжүүлэх ажлыг энэхүү тогтоол батлагдсан өдрөөс хойш хуульд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэхийг “Блюскай секьюритиз ҮЦК” ХК /А.Ариунтуяа/-д, “Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д даалгасугай.

3. “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлж үлдсэн хувьцааг хаалттай хүрээнд Их Британийн Нэгдсэн Вант Улсын “Блюкорт” ХХН-д компанийн Төлөөлөн удирдах зөвлөлөөс тогтоосон үнээр худалдахаар санал болгохыг зөвшөөрсүгэй.

4. “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжинд худалдан авах эрхийн дагуу хувьцааг худалдан авах хүсэлтийг хүлээн авч дуусгах, нэгдсэн бүртгэл гарган худалдан авсан үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх, үлдсэн үнэт цаасыг хаалттай хүрээнд санал болгон гаргах, анхдагч зах зээлийн арилжааг зохион байгуулахыг

050920

“Монголын хөрөнгийн бирж” ХК /Д.Ангар/-д, “Блюскай секьюритиз ҮЦК” ХК /А.Ариунтуяа/-д үүрэг болгосугай.

5. Тус компанийн нэмж үнэт цаас гаргах шийдвэрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Блюскай секьюритиз ҮЦК” ХК /А.Ариунтуяа/-д, “Евразиа капитал холдинг” ХК /Б.Оюунболд/-д үүрэг болгосугай:

1/ “Блюскай секьюритиз ҮЦК” ХК-ийн компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас нэмж үнэт цаас гаргах шийдвэр гаргасантай холбогдуулж нийт хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд худалдан авах эрхээ хэрэгжүүлэх, өөрийн эзэмшиж буй хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх талаарх холбогдох арга хэмжээг Компанийн тухай хуулийн 38, 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэлийг ажлын 10 хоногт багтаан тус Хороонд тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;

2/ нэмж гаргасан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа явагдсанаас хойш ажлын 5 хоногт багтаан компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг холбогдох баримтын хамт Хороонд ирүүлэх.

6. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Санхүүгийн зохицуулах хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг цаг тухайд нь тогтмол ирүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Блюскай секьюритиз ҮЦК” ХК /А.Ариунтуяа/-д үүрэг болгосугай.

7. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд, үйл ажиллагаанд нь хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Т.Жамбаажамц/-т тус тус даалгасугай.

ДАРГА



З.НАРАНТУЯА